

## ТҮҮХ, СОЁЛ

Л. Лувсанчүлтэм

**ХЯТАДЫН ИХЭТУАНИЙ БОСЛОГО БА МОНГОЛ**

XX зууны сүүлчээр хятадын ард түмэн харийн түрэмгийллийг эсэргүүцэн эх оронч хөдөлгөөнийг газар сайгүй улам хүчтэй өрнүүлж байсан байна. Тэдгээр хөдөлгөөний дотроос Ихэтуаний хөдөлгөөн нилээд дээгүүр суурийг эзэлдэг. БНХАУ-д Ихэтуаний хөдөлгөөний холбогдол бүхий ховор чухал хятад материалыг 1953 онд эмхтгэн дөрвөн боть болгон хэвлэжээ. Ихэтуаний хөдөлгөөний талаар БНХАУ-ын түүхчдээс гадна гадаадын эрдэмтэн мэргэд ихэд судалж судалгааны олон тооны зохиол, өгүүлэл бичиж нийтлүүлжээ. ЗХУ-ын эрдэмтэд Ихэтуаний хөдөлгөөнийг марксист-лениннист арга зүйн үүднээс шинжлэн судалж нилээд тооны судалгааны дорвилог бүтээлүүдийг бичиж нийтлүүлжээ.<sup>1</sup>

1898—1900 онд Хойт Хятадын нутагт империализмын колоничлолыг эсэргүүцэн гарсан ард түмний зэвсэгт бослогыг Ихэтуаний бослого гэж нэрлэдэг. Энэ бослогын улмаас Манж Чин улс гадаад олон улстай эвдэрч, дайн байлдаан явуулсан билээ. Тэр цагт Манж гүрний ноёрхолд Монгол, Хятад хоёр улс хэвээр байж байсан болохоор манжчууд гүрний дотор гарсан «самууныг» дарж устгахын тулд Монголоос цэргийн дайчилгаа явуулж, манжийн цэргийн уналга болон хүнсний мал юм бэлтгэх ажилд болон дайны торгуул төлөлцөх зэрэгт монголын ард түмэн хятадын ард түмний нэгэн адил хэлмэгдэж байжээ.

Манжийн засгийн газар Европ, Америк, Японы хөрөнгөтөн түрэмгийлэн орохыг хааж чадахгүй, харин тэдгээрийн өмнө ямагт бууж ухрах бодлого баримталдаг болсонд хятадын өргөн олон ард түмний дургүйцэл ихэд өрнөв. Ялангуяа хятад-японы дайны сүүлчээр хүнд хүчир албан татвар ард иргэдийн нуруун дээр шинээр нэмэгдэн овоорч, хоосрол ядуурал ихэдсэн ба гадаадын хөрөнгөтнүүд барга зэрэг монгол хошуудын нутгаар төмөр зам тавьж үйлдвэр уурхай нээснээр малын билчээр ба тариалах газар хомсдсон байна.

Эдгээр шалтгаанаар колоничлогчдыг үзэн ядаж, үлдэн хөөх санаа газар сайгүй дэлгэрч, юуны түрүүнд улс орны хууль дүрэм, зан заншлыг зөрчиж, дураараа аашлагч католиг шашинт хар лам нарын эсрэг тэмцлээ чиглүүлж байв. Энэ хэрэг явдал буюу Ихэтуаний бослого нь Европ дахинд, «боксерын» бослого гэж алдаршжээ.

1898 оны үед хятадын либерал сэхээтэн нар өөрийн орныг колонийн дарлалаас реформын замаар аварч гаргахыг оролдож байжээ. Гэтэл 1898-1900 онд хятадын эгэл жирийн тариачин ардууд реформын замаар бус, өөрийнхөөрөө улс орноо аврахын тул хөдөлгөөн гаргажээ. Энэ хөдөлгөөн нь туйлын хоцрогдсон бөгөөд дундад зууны хэлбэрээр явагдаж байлаа.

1. Н. М. Калюжная. «О содержании прокламации нагисанных участниками восстания Ихэтуаней»-«Краткие сообщения Ин-та народов Азии (АН СССР)», № 71, М., 1964, с. 133--- 142; А. С. Костяса. Народные движения в Китае в 1901—1905:-«Краткие сообщения Ин-та нароодв Азии (АН СССР)», № 85, М., 1964, с. 72-84 гэх мэт.

Тэд нар Күнзийн номлол ба хятад арьснтыг хамгаална гэсэн уриа дэвшүүлсэн ажээ. .

Хөдөлгөөнд оролцсон сэхээтний төлөөлөгчдийн зарим нь империалистуудыг эсэргүүцсэн сэдэвтэй шог нийтлэл олныг зохиож, бүх улс даяар тарааж байжээ. Жишээ нь: «Шулмасын ном сөнөтүгэй», «Шулмасыг сөнөөх дуу» болон хар лам нарын амьдралыг дүрслэсэн элдэв шог зургууд болно.

XIX зууны 80-аад оноос эхлэн гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг аяндаа гарч байсан хятадын ард түмний эсэргүүцэл тэмцэл нь хар лам! нар ба христосын мөргөлтэй хятад хүмүүсийг гадаад гүрний тагнуулч гэж довтолдог үндсэн хэлбэртэй байжээ.

Хятад-Японы дайны уршгаар хойт хятадын зарим нутагт байдал хурцадсаны улмаас «том илд» гэдэг нууц эвлэл хүчээ хуримтлуулсаар 1895 оны зун Шаньдун мужид гадаадын шашин нэвтрүүлэгчдийн эсрэг бослого гаргаад христос мөргөлтний орон байшин, дэлгүүр болон орон нутгийн захиргааны байрыг бут цохьж эхлэв.

Иймд босогчдын өөдөөс номещикийн сайн дурын цэрэг ба засгийн газрын цэргийг хөдөлгөсөн учир бослого нэг сар хиртэй үргэлжлээд дарагджээ.

Энэ «том илд» гэдэг нууц эвлэлийн удирдлагын дор гарсан бослого дарагдсаны сүүлээр Чжили мужийн захын нутагт «Ихэтуань» («энх ба шударга ёсны эвлэл») гэдэг бүддийн шашны нууц бүлэг үйл ажиллагаагаа идэвхжүүлж эхлэв.

Энэ бүлгийн хүмүүс-ихэтуаньчууд анхандаа өөрийн онгод бурхадыг тахиж, шашны дүрмээр мөргөл хийх ба хар лам нарыг харааж зүхэх зэргээр ажиллаж байсан ажээ. Гэтэл гадаадын түрэмгийлэл улам улам их болж ирсний улмаас 1898 оны 1-р сараас эхлэн ихэтуаньчууд зэвсэг барьж эхлэсэн бөгөөд тэдний тугийн дор зүг бүрээс тариачид цутган иржээ. Гадаадын түрэмгийлэгчдийн дарлал мөлжил нь тухайн үед нийт Хятадын бүх хүчийг нэгтгэн тэмцэх бодит нөхцөл бололцоог бүрдүүлэн байв. Империалистуудын түрэмгийллийг эсэргүүцсэн ихэтуанний хөдөлгөөний үндсэн бааз нь 1898 он хүртэл Шаньдун мужид байжээ. Мөн оны намраас эхлэн зэргэлдээ Чжили мужид ардын хөдөлгөөн үргэлжлэн гарчээ. 1899 оны сүүлч-1900 оны эхээр Шаньдун мужийн албаны цэрэгтэй илд жад төдий бүдүүлэг зэвсгээр зэвсэглэсэн ихэтуаньчууд тулалдаж түр зуур ялагдал хүлээжээ. Байдал ийм болсноос бослогын гол хүч Шаньдунгаас гарч, Чжилид шилжсэнээс хойш хэдхэн сарын дотор бүх мужийг хамрав. Ийм байдлаар бослого улам дэлгэрсээр Өвөр Монголын Зууудын чуулган, Цахарын хошууд, Шилийн голын чуулганы баруун, зүүн Үзэмчины зарим хэсэгт хүрч улмаар зүүн хойш Манжуурт ороод шинэ, хуучин Баргыг хамарчээ. Ялангуяа Барга монголын Хайлар хот ба Зууудны Баарин бэйс Дүйнхаржавын хошуунд Ихэтуаний нөлөө онцгой хурц туссан учир тэндэх монголчууд ихэд үймэлдсэн байна.

Ихэтуаньчуудаас олон түмнийг ятган ухуулах бичгийг удаа дараалан гаргасан бөгөөд түүнд далдыг мэдэх ёс, төлөг үзэж мэргэлэх, бэлэг тэмдэг, ёр шинж тэргүүтэн сүжиг бишрэлтэй холбогдсон зүйлүүдийг бичсэн байв.

Хятадын шашны номлолоор туг хийж нэгдэн боссон босогчид өөрсдийн Онгон бурхадын тусламжаар гадаадынхныг амархан дарж чадна гэж бүрэн итгэсэн байжээ. Тэд хамгийн түрүүнд христосын шашинд орсон хятадуудаа алж, христосын сүм дуганыг шатаагаад улмаар төмөр замыг эвд, цахилгаан утасны баганыг унагаа, уурын онгоцыг устга гэх мэт учир зүйгүй

олон уриалга гаргажээ. Гэвч энэ нь тухайн үедээ биелэгдэх нөхцөлгүй байжээ. Ихэтуаньчууд Франц, Англи, Америк, Япон, Итали, Герман, Орос зэрэг империалист улс гүрнүүд хятадаас зайл гэж хашгиралдаж байжээ. 1900 оны 5-р сард Тянь-цзиний районд босогчдын үлэмж тооны хүч бөөгнөрч, тэмцэл их л ширүүсэн хурцдаж, байдал сүрхий болсонд гадаад гүрний засгийн газруудаас босогчдыг нэн даруй номготгохыг манжийн талд шаардаад хэрэв эс хэрэгсэвээс өөрсдийн зэвсэгт хүчийг хэрэглэхээр сүрдүүлжээ.

Мөн оны 6-р сарын эхээр уур хилэн нь бадарсан босогчид Бээжин Тяньцзиний төмөр замыг тасдан эвдэж, Бээжин болон бусад хотууд дахь Англи, Америкийн худалдаачдын дэлгүүр агуулахыг нэгэн зэрэг галдан түймэрджээ..

Тэрчлэн Европын бараа таваар худалдаалдаг хятад дэлгүүрийг нэгэн адил галдан шатааж, дэлгүүрийн эзэн хятадуудаа буруу номтны талын этгээд гэж хараан зүхэж гудамжинд чирэн аваачаад христосын сүм дуганыг шатааж, хар лам нарыг хөөж зугадуулав.

В. И. Лениний бичсэн нь: «Хятадууд европын ард түмнийг үзэн яддаг бус харин Европын капиталистууд, тэдний үгнээс гаждаггүй Европын засгийн газруудыг үзэн яддаг юм. Зөвхөн баяжихын төлөө хятадад ирдэг, зөвхөн хууран мэхлэх, дээрэмдэх, хүчирхэхийн тулд гайхуулан магтдаг соёлоо ашигладаг, ард түмнийг мунхруулагч хар тамхи худалдах эрх олж авахын төлөө Хятадтай дайн хийдэг дээрмийн бодлогыг христосын шашныг дэлгэрүүлэх явдлаар нууцлан бүрхэгдүүлдэг хүмүүсийг хятадууд хорсон үзэн ядахгүй байж болох байсан уу?»<sup>2</sup> гэжээ.

Босогчид хэдийгээр харанхуй бүдүүлэг, сүжиг бишрэлд автсан боловч империалистуудаас эх орноо хамгаалах сайхан зорилтыг удирдлага болгосон ажээ.

Аяндаа гарсан бослого бол удирдлагагүй бөгөөд босогчдыг хошуучлан дагуулагч нь ямагт ёс шиг алдаршаагүй хүмүүс байдаг байлаа. Жишээ нь: Тяньцзиний районд завьчин иргэн Чжан Дэ-чен, тэнүүлч иргэн Цао Фу тен нар бослогонд толгойлогч болсон байна.

Тэр хоёрын дор 100 мянга орчим хүн цугларсан ба улаан, шар, хар, цагаан өнгийн тойлгойн алчуураар ялгах тэмдэг болгож, анги, багаар хуваагдаж байв, Босогчдын эгнээнд ихэвчлэн тариачин, гар урчууд, худалдаачин, тээвэрчин, гол мөрний завьчин, халагдсан цэргүүд оролцсон бөгөөд бас ангийн чанараа алдсан этгээдүүд хүртэл нэгджээ. Босогчдын олонхи нь залуучууд байсан ба тэд заримдаа өөрсдийн отрядын өмнө Улаан дэнлүү барьсан бага охиныг явуулж, ямар ч гэмгүй охин шулмасын бууны суманд оногдох ёс үгүй, том хүмүүс ч тарни уншваас мөн ажрахгүй гэдэг байжээ.

1900 оны 6—7-р сард Тяньцзиний районд нэг талаас босогчид (Ихэтуаньчууд), нөгөө талаас империалист найман холбоотон гүрний нэгдсэн армийн хооронд тулалдаан болов. Үүнд босогчид маш их хохирч байсан боловч амь хайргүй тулалдсаар байжээ. Ширүүн догшин тулалдааны үед бослогын хошууч Чжан Дэ-чен, Цао Фу тен нар хүнд шархдаад баригдаж алагджээ. 8-р сарын 3-наас эхлэн холбоотны арми Бээжин рүү давшсан бөгөөд зэвсэг ба зохион байгуулалтын талаар ихэтуаньчуудаас давуу тул байлдааны явцад асар олон хүнийг устгаж байлаа.

Ихэтуаньчууд эхлээд тэмцлийн хурц үзүүрээ гадаадынхны эсрэг чиглүүлсэн учир Манжийн хааны засгийн газар, Ихэтуанийг талархан дэмжиж, хэсэг зуур хууль ёсны болгож байлаа. Жишээ нь: Энэ хэрэг

явдлаас болж гадаад олон гүрэнтэй дайны байдал бүхий болсон тухай 1900 оны 5-р сарын 25-нд Халхын аймаг, шавийн ноёдод зарлан мэдэгдсэн нь: «Гадаадын хүмүүс манай улсад өөрийн шажны сургаалыг уламжилж гучаад жил болов. Одоо тэд нар санамсаргүй байтал гэнэт дэмий аашилж, манай улсыг хашраан дарлах ба манай газар орныг эзлэх ба манай ард иргэдийг зовоосон хийгээд манай эд юмыг албадан авч байна. Үүнд манай ард түмэн өшөө хорсолтой болж, хүн бүр хариу авахыг хичээсэн учраас христосын сүмийг шатааж, хар лам нарыг алсан нь энэ учир болой. Нийслэл хот ба Шаньдун мужид журамт шаламгай ардууд (ихэ туаньчууд) хуралдсан нь хэд хэдэн арван түмэн хүн болсон төдийгүй бага хүүхэд хүртэл улсыг хамгаалан байлдах дайралдахыг санажээ. Манай газар орон уудам, хүн иргэн үлэмж, дайсанд хялбар шоглогдохгүй буй заа»<sup>3</sup> гэжээ. Үүнээс үзэхэд гадаадын империалистын түрэмгийллийн эсрэг чиглэсэн ихэтуаний бослогыг манж гүрэн битүүдээ дэмжин ашиглахыг оролдож байсан тал харагдаж байна. Түүнээс хойш өдөр өнгөрөх дутам бослогын хүч далайц ихдэж, тэмцэл улам хурцадсан бөгөөд босогчдын шаардлагаар Манжийн засгийн газар Англи, Франц, Герман, Америк, Орос, Япон, Итали, Австри улсуудад дайн зарлаж, Бээжин дэх тэдний элчин нарыг зайлж одохыг шаардав. Гэтэл гадаадын элчин нар гарахыг татгалзсан ба харин тэдний засгийн газрууд энэ хэрэг явдлыг аятайхан шалтаг болгон ашиглаж, өөрсдийн бүслэгдэн хаагдсан элчин нар болон тус тусын харьяат иргэдийн амь бие, эд хөрөнгийг хамгаалах нэрийдлээр хамтран цэрэглэж, бослогыг дараад хятад дахь ноёрхлоо бэхжүүлэхээр шийдэх зэвсэгт хүчээ нэгтгэн ажиллуулав. Холбоотон гүрний цэрэг хүрз шийдэм барьсан босогчдыг үй олноор хядсаар 8-р сарын 15-нд нийслэл Бээжин хотыг хялбархан эзлээд хааны орд харш, уран гоё барилгуудыг эвдэн сүйтгэж, олон яам, албан газрын байшинд гал тавин шатаасан ба хааны сан дахь үнэт эрдэнэс, ховор нандин юмыг дээрэмдэн талж, баян худалдаачдын эмс, охидыг хүчирхэн эдлэж, эрчүүдийг зэрлэгээр алан хядаж ялалт байгуулжээ.

В. И. Лениний бичсэн нь: «Үнэндээ энэ ялалт нь дайсны байнгын цэргийг ялахаасаа хятадын босогчид, чингэхдээ гартаа зэвсэггүй хятадуудыг ялжээ. Гартаа зэвсэггүй хятадуудын орд харш орон байр, дэлгүүр, мухлагийг дээрэмдэхээр барахгүй хүүхэд эмэгтэйчүүдийг зодож занчиж, алж хядахаас буцахгүй байна»<sup>4</sup> гэжээ.

Ихэтуаний бослого цааш өрнөхдөө гагцхүү гадаадынхан төдийгүй, дотоодын зарим феодал, газрын эзэдтэй тэмцэл явуулж эхлэсэн бөгөөд уг хэрэг явдал улам гүнзгийрч ирсэнд Манж, Хятад түшмэд ихэд айн цочиж, Ихэтуаныг талархан дэмжих байтугай, харин тэдний эсрэг гэнэт залхаан цээрлүүлэх арга хэмжээ авчээ.

Энэ тухай Манжийн засгийн газрын Их зургаанаас гаргасан ухуулах бичигт: «Манай улсын өөдгүй хүмүүс (Ихэттаньчууд) цуу үг дэгдээн, олон түмнийг самууруулан буй, тэднийг дагалдан аж ахуйгаа орхиж, дэмий үймэлдвээс үл болно»<sup>5</sup> гэж бичсэн байна. Энэхүү ухуулах бичгийг Ар Монголын Их Хүрээ, Хиагт, Улиастай, Ховд зэрэг хот суурин болон олон сүм хийдийн гудамжаар нааж, бас аймгуудын жасаа, хошуудын тамгын газруудад тараан өгч байв. Нийслэлийг эзлэгдэхийн өмнөхөн Манжийн хатан хаан Си тайхоу Бадаргуулт төр хаанаа авч Сиань хотод нүүж очоод урьд зарласан бодлогоо орхиж, хэрэг явдлын бүх бурууг ихэтуаньчуудад

3. УТТА. Ф. № I, ХН. 2239, т. 34—35.

4. В. И. Ленин, зохиолууд, 4-р боть, 371-р тал.

5. УТТА. Ф 2-23-9

тохоож, бослогыг дарах тухай өөрийн цэрэгт тушааж байв. Ингэж Манжийн засгийн газрын бодлого бүрмөсөн урвасан ба Бээжин хот эзлэгдсэнээр босогчдын тэмцэл зогссонгүй, хоёр жил илүү гадаад, дотоодын цэргийн хүчний өөдөөс тулалдсаар байгаад дарагдсан болой.

Ихэтуаньчууд ба холбоотон гүрний хоорондын цэргийн мөргөлдөөний үед Манж гүрний улс орны байдал нилээд бэрхшээлтэй болжээ. Тэр үед манжийн засгийн газар холбоотон гүрний нэг-Хаант Оросын цэрэг умар талаас Манжуур болон Монгол руу түрэмгийлэх болзошгүй, бас Ихэтуаний нөлөө Ар Монголд халдах болов зээ гэж сэжиг таавар төрж, Халхын цэргийг нэн түргэн дайчилж, нутаг орноо «батлан хамгаалахын» хамт орос цэргийн байдлыг тасралтгүй тагнан мэдээлж байхыг Хүрээ, Ховдын амбан, Улиастайн жанжин нарт даалгаж ажиллуулсан байна.

Манжийн цэргийн зөвлөлөөс 1900 оны 5-р сард уламжлан ирүүлсэн Манж хааны зарлигт: «...эдүгээ Дундад улстай гадаад улс байлдаан үүсгэв. Монгол нутаг Орос улстай зэргэлдээ буй, иймд монгол ван, гүн нарт яаравчлан зарлаж, цэрэг бэлтгэн хязгаарыг сэргийлүүл»<sup>6</sup> гэсэн ба цэргийн зургаанаас ирүүлсэн өөр нэгэн бичигт «Оросын морьт цэргийн анги хуурай замаар орж ирэх чимээ буй тул сайтар тагнан сурвалжилж мэдээг арав хоног дутам ирүүлж байсугай»<sup>7</sup> гэжээ. Үүнд: Хүрээ, Улиастайн манж, хятад ноёд, гадаадын дайсан, «дотоодын самуун» гэгчээс Халхыг хамгаалах нэрийдлээр дөрвөн аймгийн чуулган дарга, их шавийн эрдэнэ Шанзудба нарт өдөр шөнийг хэрэгсэхгүй элч бичиг нисгэн довтолгож, цэрэг дайчлан татах ажилд Ар Монголын хүчийг ашиглахын тул 20,000 халх цэргийг дайчлан татахаар шийдээд эхний ээлжинд Түшээт хаан аймгаас 2000 цэрэг дайчилж, Хүрээний баруун этгээд засаг Мандарваагийн хошууны нутаг Урт гэдэг газар, Цэцэн хан аймгаас 2000 цэрэг дайчлан Хүрээний зүүн этгээд Уу-булан гэдэг газар тус тус суулгаж, их шавийн 1000 цэргийг Хүрээнд суулгав. Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгаас дайчилсан 2200 цэргийг Улиастай хотын дэргэд байрлуулжээ.<sup>8</sup>

Энэ үеэр Оросын талаас хилийн ойролцоо цэргийн сургууль явуулах буюу Алс дорно руу цэрэг илгээх зэргээр дайнд холбогдох ажлаа идэвхжүүлсэн зэргээс Хүрээний манж амбан, Бээжингийн Манжийн засгийн газар ихэд болгоомжлон хардаж сэрдэж байв. Гэтэл Цэцэн хан аймгийн засаг бэйс Цэрэннамжилаас «Амбан хотод байлдаан болсон учир Солози, Барга, Өөлдийн олон тооны ард айж сандран, Халхын хил давж, чуулган дарга Доржпалам, дэд даргад Цэрэннямын хошуунд нүүн ирэв»<sup>9</sup> гэж мэдүүлж байжээ. Мөн зүүн хоёр аймгийн харуул захирагч Ламжавсүрэнгээс «Манай Хөвөлзөх харуултай хайч нийлдэг Хөлөн буйрын харъяа Цагаан уул харуулын түшмэл цэргүүд Амбан хотод байлдаан болсонд харуулыг хаяж зайлжээ<sup>10</sup> хэмээн бас Хүрээний амбан сайд нарт мэдүүлцгээсэн байна. Энэ мэт монгол газраас цэрэг, эр дайчилж байсан баримт материал их байна. Гэвч Манжийн засгийн газрын шийдвэр Ар Монголд бүрэн гүйцэд хэрэгжиж чадаагүй байна. Тухайн үед Монголын ард түмэн хятадын ард түмний нэгэн адилаар манжийн төрийг түлхэн унагааж тусгаар тогтнолоо олох гэж байсан болохоор түүхийн бодит нөхцөлд тийм шаардлага биелэгдэх нөхцөлгүй байжээ.

Манж улс, ихэтуаний хэрэг явдлаас сөдөгдөж гадаад гүрнүүдэд нэг үе дайн зарласны улмаас Чуулалт хаалга зэрэг хотуудаас хүрээнд нэвтрэх

6. УТТА. Ф. 4—26—261

7. УТТА, ф. 4—26—51

9. УТТА. Ф. 4—26—3

10. УТТА. Ф. 11—4.

гол зам хаагдаж, дорнод Монголд орох элдэв бараа юм тасалдсан ба Орос газраас орох бараа бараг зогссон тул Түшээт хан, Цэцэн хан аймаг даяар өргөн хэрэгцээний бараа ховордов.

Ихэтуаньчууд Европын болон япон бараа худалдах буюу худалдан авсан хүмүүсийг тэрс номтны тал гэж барин алж байсан учир монгол хүмүүс Хүрээ, Хиагт ба хөдөө бүхий пүүснээс бараа авахад бэрхшээл учирч, арга буюу зайлсхийх болов.

Жишээлбэл, хятадын аль нэг дэлгүүрт европ буюу японд хийсэн цаасан тамхи, цаастай чихэр, лаа, ламп, нүдний шил мэтийн юм харагдвал ямар ч хүн наймаа хийхээсээ болгоомжлох болсон. Тэр ч байтугай хятадын босогчдоос болгоомилж Хүрээ, Улиастай, Ховд болон хөдөө дэх монгол газар байсан оросын Дэлгүүр мухлагт нэг хэсэгтээ монгол хүн орохоос бас болгоомжлоход хүрч байсан байна. Олон хошуун дахь хятад пүүсүүд ч гэсэн мөн ихэтуаньчуудаас айн эмээж гадаад орны бараагаа нуун далдлах буюу дэлгүүрүүдээ хаагаад худалдаа наймаа хийхгүй болжээ.

Эдгээр шалтгаанаас будаа, гурил, цай, тамхи, даавуу, даалимба мэтийн өдөр дутмын хэрэгцээний бараагаар монголчууд гачигдах байдалд учирч байв. Энэ тухай Хүрээн дэх сайдын яамнаас «Хүрээ, Хиагтын худалдаа улмаар буурав. Хятадын пүүсэнд байгаа гадаад орны бараа таваарыг айн болгоомжлон худалдан авахгүй болов. Бид нийтэд ухуулан зарлаж, хуучин байгаа барааг худалдуулан монгол ардуудыг гачигдуулахгүйг хичээн байна»<sup>11</sup> гэж Дотоод зургаанд явуулсан бичигт өгүүлжээ. Иймэрхүү материал манж хэлээр улсын архивт цөөнгүй байна.

\* \* \*

Холбоотон гүрний хамтарсан хүч, зэвсэг, сургууль муутай манжийн цэргийг түргэн хугацаанд бутцохисон сул Чин улс аргагүй ялагдсанаа хүлээв

1901 оны 9-р сард Манж улс холбоотон гүрэнд буун өгч, тэдний тулгасан үлэмж хэмжээний дайны торгууль болон бусад хүнд хэцүү зүйлийг хүлээлгэсэн дээрмийн гэрээнд газын үсэг зурав. Энэ гэрээгээр холбоотон гүрэнд 450000000 лан мөнгө төлөх болсноос гадна Манж улс гадаадаас цэргийн зэвсэг авахгүй байх, олон гүрний элчин консул, хар лам, худалдаачдыг хамгаалах гадаадын цэргийг Хятадад байнга суулгах, хойч өдөр «Дундад улсын нутагт гадаадын хүнийг өшөөлж сүрэглэн эсэргүүцэхийг үүрд зогсоох тухай зарлигийн бичгийг улс даяар хоёр жилийн турш нааж ухуулах, хэрэв дахин харь гүрний хүн иргэдийг хорловоос алах ял шийтгэх, гадаадын хүнийг хөнөөн дарлаваас тэр хотын бичгийн хүмүүсийн эрдмийн зэрэг хамгаалахыг зогсоох, харъяат түшмэдийг зэрэг эвдэж, үүрд хэрэглэхгүй болгох»<sup>12</sup> гэх мэтийн урьд өмнө гараагүй доромжлолыг хүлээжээ. Арга нь тасарч, хүч нь мөхөсдсөн Манж гүрний засгийн газар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нөлөө бусдаас илүү хурдан дэлгэрч болох нөхцөлтэй байсан Ар Монголд гэрээний бүх заалтыг нарийн чанд дагаж мөрдөхийг юуны өмнө чандлан тушаасан байжээ.

Манж гүрэн ялагдаад олон улсын хүчирхэн хүлээлгэсэн дайны торгуулийг төлөхдөө Дайчин улсын бүрэлдэхүүнд багтсан хятад, хотон, монгол, түвэд зэрэг бүх угсаатан үндэстний ард түмнээс гаргуулан авсан бөгөөд үүний дотор Халх Монголын дөрвөн аймгийн олон хошуу ба Их шавийн ард түмнээс бүгд 350,000 лан мөнгө албадан авсан байна. Үүнээс гадна холбоотны тулгасан зүйл зүйлийн шаардлага нэхэмжлэгүүдийг үг дуугүй

11. УТТА. Ф. № 1, ХН. 1397, т. 61.

12. УТТА. Ф. №. 1, ХН. 2268, т. 306—308.

13. УТТА. Ф. 4—26—45.

биелүүлдэг боллоо. Жишээ нь, Ихэтуанний бослогын үед гадаад улсын хүний амийг хорлосон этгээдийг заавал олж шийтгэсүгэй гэсэн учир бослого болсон бүх газар орны их бага тушаалын манж, хятад, монгол түшмэдийг толгой тоолон баривчилж, заримыг цавчин алж цаазаар аваачин, заримыг адгийн хязгаарт цөлж, үүрд эргэхгүй болгосон, заримыг зэрэг эвдэж дахин хэрэглэхгүй болгон шийтгэсэн бөгөөд эдгээрийн дотор 11 монгол түшмэл ял хүлээжээ. Бас нуугдсан, оргосныг олж барих, мөн бослогын үеэр холбоотон гүрний иргэдэд учирсан эд материалын хохирлыг арилгах гэж онцгой арга хэмжээ авч байв. 1901 оны 1-р сарын 17-нд Манжийн гадаад хэргийн зургаанаас Хүрээний сайдаар уламжлан Халхын бүх аймагт яаралтай зарласан бичигт өгүүлсэн нь: «Туули түшмэл Цогт (харчин монгол) ихэтуаньд элсэж, яны (европын) хүнийг хөнөөн алсан бөгөөд баригдахаас хоёр өдрийн өмнө гадаад монгол руу оргожээ. Ялт монголыг хэн олж бариваас цэрэг, иргэнийг бодохгүй нэгэн түмэн лан мөнгө шагнана, мэдээ өгвөөс 2000 лан мөнгө шагнана»<sup>14</sup> гэсэн, бас дараагаар энэ тухай Монгол зургаанаас яаравчилан зарласан нь: «Ялт монгол Цогтыг жинхэнэ тушаалын түшмэд олж бариваас хэтэрхий хөхүүлнэ, орон хүлээх түшмэл болбоос даруй түшмэл тавина. Цэрэг иргэн алин боловч уг хэлэлцсэн ёсоор нэгэн түмэн лан мөнгө шагнана»<sup>15</sup> гэжээ. Энэ Цогтыг барьж, шагнал олохыг хүссэн манж, хятадууд Ар Монголын нутгаар хичнээн эрсэн боловч олоогүй. Үүнээс гадна европын зарим орны худалдаачид, хятад газраас их хэмжээний цай бараа бөөнөөр авч монгол нутгаар дамжуулан нэвтрүүлж байсан бөгөөд энэ цайг Чуулалт хаалга хотоос Хиагт хүрэхэд монгол жинчин ихэвчлэн тээвэрлэж байжээ. Ихэтуаньчуудын боссоныг монгол жинчид мөн мэдэж байсан тул бослогыг далимдуулан өөрсдийн тээвэрлэсэн цайг Хиагт хүргэхгүй хээр газар буулган орхиж үрэгдүүлсэн зэрэг үзэгдэл нилээд гарч, тэдгээр худалдаачдыг «хохируулсан» ажээ. Бослого дарагдсаны дараа гадаадын олон элчингээс Манжийн засгийн газарт өөрсдийн харьяат худалдаачдын хохирлыг нөхүүлэхээр нот бичсэнд Манжийн гадаад яам Халхын зүүн хоёр аймаг, их шавийн эрх баригчдад тушааж төлүүлэхээр албан захидалд бичсэн нь: «Яны (европын) хүмүүсийн цай Сарааг зам зуур хаян үрэгдүүлсэн нь буй ахул харьяалах хошууны түшмэдэд тулгаж төлүүлсүгэй»<sup>16</sup> гэсэн учир Хүрээний амбан худалаачны нэхэмжлэн шаардсан үлэмж тооны цай барааг аянчин жинчны замд тохиолдсон хошуу, шавийн ардуудад нүд балай тулган тэлүүлжээ. Эдгээрээс үзвэл манж ноёд гадаад гүрний даралт шахалтаар юу ч хийхэд бэлэн болтлоо бууж өгсөн нь тодорхой байна.

Ихэтуаны тэмцлийн чимээ анир Ар Монголын ард түмний дотор сонсдоод Хятадын ард түмний тэмцлийг сайшаан үзэх санаа сэтгэл улам улам дэлгэрч байжээ. Ялангуяа баруун, зүүн аймгаас шинэ татагдсан Халхын цэргүүд манж ноёдын тушаалаар ихэтуанийг эсэргүүцэн, ард түмний бослогыг даралцах буюу орос цэрэгтэй байлдаж өнө цагаас айл хөрш сууж, найрсаг амьдарч ирсэн Оросын харьяат нартай харилцаагаа муутгахыг огтхон ч хүсэхгүй байв.

Манжийн засгийн газар ихэтуаний хэрэг явдлаар далимдуулан монгол орос ард иргэдийн эртний уламжлалт худалчдаа арилжааны холбоо харилцааг бүрмөсөн таслан зогсоох оролдлого хийсэн бөгөөд гэтэл тэр доороо монголчуудын эсэргүүцэлтэй тулгарч бүтэлгүй болж байсан. Жишээлбэл, 1900 оны 6-р сарын 20-нд цэргийн зургаанаас Халхын дөрвөн аймаг, шавь

14 УТТА. Ф. 4—26—112

15. УТТА. Ф. 3—25—339

16. УТТА, Ф. 3—25—111

тавд зарлан тушаасан нь: «Оросын морьт цэрэг Монгол нутгаар орж ирэх хэмээнэ. Үүнийг монгол хүмүүст мэдэгдээд орос морь, тэмээ ба үхэр тэрэг өгч тэдний цэргийн хүнд ачааг тээхгүй болго. Бас тэдний цэргийн хүнсэнд үхэр, хонь худалдан өгөхгүй болго»<sup>17</sup> гэжээ. Үүнд зүүн хоёр аймгийн чуулган дарга нараас «Манай монгол хүн оростой харилцан найрамдаж, тэдний элдэв юмыг хөлсөөр тээж хүргэх буюу тэдэнд үхэр, хонь худалдан өгөх явдал он жил удсан бөгөөд одоо гэнэт хуучин заншлыг хувьсган халж, орос морь, тэмээ хөлслөхгүй, үхэр хонь худалдахгүй бол хуучин тогтсон найрамдал алдагдах болзошгүй тул урьдын хэвээр явуулъяа»<sup>18</sup> гэж нэгэн зэрэгээр бичиглэцгээж Манжийн дээд газрын шийдвэрийг хэрэгсэхгүй болгожээ. Ингэж монгол, орос ард иргэдийн харилцааг таслахаар оролдсонд нийт монголчуудын дунд манжийн эсрэг санаа улам өрнөх болов. Үүний нөгөөтэйгүүр Улиастайн Жанжин яам, Улиастай дахь аймгийн жасааны манж, хятад, монгол түшмэдийн хүнд суртал, хөшүүн хойрго ажиллагааны гайгаар нөгөөх оросын цэрэг ба Ихэтуаний эсрэг цэрэглэхээр шинэхэн дайчилж, Улиастай хотын дэргэд байрлуулсан Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн цэрэгт олговол зохих хүнсийг өдөр удтал өгөхгүй өлөн зэлмүүр хорьж байжээ. Хошуудаас урьд нийлүүлсэн хүнс хэдийн дуусаад бас цэргүүдийн биедээ авч явсан бага сага хуурай хүнс ч мөн барагдсан бөгөөд бас тэр жил Сайн ноён хан аймгаар ган гачаал болж, өвс ногоо ховордон, хонь мал таргагүйн дээр ан гөрөөс асар ховор байсан явдал олон цэргийн өлсөхөд нөлөөлөв. Мөн манж, хятад сургагч нар монгол цэрэгтэй харилцахдаа авир зан асар догшин бөгөөд маш ширүүн хэрцгийгээр авирлан загнадаг байсан зэргээс олон цэргийн уур хилэн гал мэт бадарч, хүч сүр хэрэглэн хүнс хоол олж идэх ба цаашид манж нарыг шахамдуулж байгаад цэргийг татан буулгуулж, гэр гэртээ харихыг зорьж бүгдээр санал нэгтгэн 1900 оны 8-р сарын эцсээр гэнэт босцгоож, Улиастайн жанжин, хэвэй амбан, түшмэдийг үхтэл айлгажээ.

Эрх жаргалдаа ташууран мунхарсан жанжин Кин болон манж хятад түшмэд тэдний дэргэд байсан хоёр мянган халх цэрэг бослого гаргасныг мэдэхгүй, орд өргөөндөө санаа амар наргин цэнгэж суутал боссон цэргийн шаламгай эрчүүд шатсан гал шиг, хотын дүүрэг дэх төмс, ногооны газрыг сүйтгэж, хятадын дэлгүүр мухлагийг бусниулан улмаар жанжин яамны ойрхи гэр, байшингуудад түрэн орж, ийш тийш гүйлдэн эндэх тэндэхийг бусниулан унагааж, ноёдын пүүст хүрэм, жинст Малгайг урж хаялан, ширээ исэр, сандал түшлэгийг хэмхчээд жанжин яамны оршин байдаг сангийн хойт цайзыг бүсэлж, цэргийг даруй түргэн татан буулгаж гэр гэрт нь буцаагтун гэж зэрэг зэрэг шаардан хашгиралдав. Манж ноён элэг цөс хэмхэртэл айж, далдлах газар, нуугдах нүх эрж зугтан зайлцгаав. Жанжин яамны дотор байсан манж түшмэд (хапан) нар зайлж гарах завдалгүй болж, байшин барилгын доогуур шургацгаав. Мөн энэ цэргийн бослого болоход Улиастайн хол дахиныг тогтоогч сүмийн лам нар болон хятадын баян худалдаачид дүрвэн зугтсан бөгөөд энэ тухай Бээжин дэх Монгол зургаан анхны бараг бүрэг мэдээ сонсоод «Улиастайн хоёр хотын (Сангийн цайз хот, худалдааны зээл хот) хүмүүс сууж бүхий газраас зайлан нүүж буй хэмээнэ. Нүүгсэд чухам ямар шалтгаанаас болсныг тодорхойлно уу»<sup>19</sup> гэж Улиастайд яаравчлан бичиг ирүүлж байснаас үзэхэд, энэ бослого ихээхэн дуу цууриатай хэрэг явдал болсон нь тодорхой байна. Жич энэ цэргийн бослогын тухай Улиастайн жанжин яамны архивын ма-

17. УТТА. Ф. 2 1. ХН. 1011, т. 167

18. УТТА, Ф. № 1, ХН. 1012, т. 168.

19. УТТА. Ф. № 8. ХН. 1361, т. 6.

териалаас нэмэн тодорхойлбол Халхын дөрвөн аймагт цэргийн дайчилгаа явуулаад Сайн ноён хан аймгийн мянган цэргийг «Ж» хороо болгон зохиож (Одоогийн Завхан аймгийн Цагаан-хайрхан сумын нутагт) Хөшөөт гэдэг газар суулгасан байв. Гэтэл мөн хорооны цэрэг чин ван Цэрэндондовын хошууны онолт гэгч «Хоол унд муутай сууж чадахгүй, бүгдээр нутаг гэртээ буцаа» хэмээн олон цэргийн дунд уриалсанд цэргүүд зөвшөөрөлдөн тэр доороо дарга, захирал нартайгаа цуугиан үүсгэж, гэр гэртээ буцахаар тарж эхэлсэн бөгөөд энэ чимээг Улиастайн дэргэд суулгасан Засагт хан аймгийн «у» хороонд сонсдогч мөн цэргүүд гэдэс өлсөв хэмээн шуугилдан занги захирлуудын үгийг үл даган, хуаранг орхиж хошуу хошуундаа буцсан байна.

Үүнд Улиастайн манж жанжин машид уурлаж, дур зоригоор алба хаяж явчихсан цэргийг нэгд нэгэнгүй олж, хороо ангид нь оруулахыг харьяалах газруудад болзоо тогтоон тушаагаад хошуудын хүчээр их төлөвийг буцаан авчирч Улиастай хотын дэргэд «Ж», «У» хоёр хороог нийлүүлэн суулгав. Манж ноёд анхандаа тэрхүү олон цэргийг тараасан гэмт этгээдийг хүндээр яллах гэсэн боловч дараа нь нийт улс орны байдал хүнд байгаа үед монгол цэргүүдийг шийтгэж болохгүй гэж үзээд «нэгэнт өнгөрсөн хэрэг тул уучлан хэлтрүүлэв» гэж зарлажээ. Чингээд удалгүй мөн оны 8-р сарын 21-нд Улиастайн жанжин яамнаас манж, хятад сургагч түшмэдийг томилж «Ж», «У» хоёр хорооны цэргийн дотоодод шинэ шинэ хатуу чанга дэглэм тогтоов.

Үүнээс хойш хэдэн өдөр өнгөрөөд сайхь Онолт болон Энхтайван зэрэг нилээд тооны цэргийн эрс тэргүүлж, хоёр мянган цэргийг удирдан дагуулж, жанжин, амбан түшмэдийн эсрэг хөдөлсөн байна. Боссон цэргүүдтэй манж жанжины 200 шадар цэрэг нийлэлдэж бас хотын зарим ядуучууд оролцсон учир их гэгчийн хэрэг мандуулж болох байв. Гэтэл монгол цэргүүд анх ийнхүү зориг зүрхтэй боссон боловч сүүлдээ бослого хүчтэй үргэлжлүүлэхийн чухлыг мэдэхгүй, захирч командласан залан, занги нарын үг ухуулгад автагдан, анхны зориг санааны эрч бууран буурсаар тэмцлээ орхин гэр гэртээ харьцаасан ажгуу.

Ш. Нацагдорж «Ар Монгол дахь ардын хөдөлгөөн» гэдэг номондоо «Улиастайн цэргийн бослого нь ардын хөдөлгөөнд байдаг тодорхой зорилгогүй, зохион байгуулалтгүй, хязгаарлагдмал байдалтай шинжийг мөн л хадгалсан байжээ» гэж дүгнэжээ.

**Л. Лувсанчүлтэм**

## МОНГОЛИЯ И ВОССТАНИЕ ИХЭТУАНЕЙ В КИТАЕ

### Резюме

Автор статьи, основываясь на архивных документах на маньчжурском языке Центрального государственного Исторического Архива МНР, анализирует малоизученный вопрос об откликах монголов на восстание ихэтуаней в Китае и политику Цинского правительства в отношении Монголии а период этого восстания.

Как известно, в 1898—1900 гг. в Северном Китае развернулось восстание китайских крестьян, вошедшее в историю Китая под названием движение ихэтуаней, а в Европе известно как «Боксерское восстание».

Маньчжурские власти в целях ведения войны с иностранными войсками и подавления восстания ихэтуаней, мобилизовали в Монголии 20 тысяч Цириков (солдат). Положение монгольских цириков в маньчжурской армии было невыносимо тяжелым. Суровый режим и тяжелая военная служба часто вызывали недовольствия среди монгольских цириков.

В период этого восстания особенно увеличились размеры различных повинностей и особых сборов военного характера, взимаемых с монгольских аратов. В этой связи автор приводит конкретные примеры. Так например, когда маньжурская армия потерпела поражение в этой войне монгольский народ вынужден был выплатить военную контрибуцию Маньчжурской империи в сумме 350.000 лан серебра. Жестокие репрессии, многочисленные налоги, грабеж и насилие маньчжурских властей в отношении монгольского народа вызывали гнев уаратов Монголии, что можно рассматривать, как косвенное влияние восстания китайских крестьян на Монголию.

В статье приводятся факты, говорящие о том, что монгольский народ активно поддержал повстанцев. Примером этому служит восстание монгольских цириков в Улясуае, отказавшихся воевать против восставших в Китае крестьян.

Во время восстания Цинское правительство больше всего опасалось сближения Монголии с Россией, распространяя слухи о вторжении войск Царской России в Монголию.

В заключение автор отмечает, что политика Цинского правительства в период восстания ихэтуаней в отношении Монголии было направлено на усиление экономического и политического закабаления Северной Монголии, колонизацию ее земель и полную изоляцию Монголии от внешнего мира.